



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 393

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон, нийт 22,658,000.00 (хорин хоёр сая зургаан зуун тавин найман мянган) төгрөгийн хавсралтад заасан хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав, Тээврийн цагдаагийн албаны дарга Д.Амарсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД

0000790

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
393 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ
БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо шир хэг	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Гэр (5 ханатай)	6,000,000.00	иж бүрэн	1	6,000,000.00
2	Ширээ /цайны/	700,000.00	ширхэг	1	700,000.00
3	Сандал /жижиг модон/	50,000.00	ширхэг	2	100,000.00
4	Сандал /модон, түшлэгтэй/	700,000.00	хос	1	700,000.00
5	Ширээ /дарга/	1,220,000.00	ширхэг	1	1,220,000.00
6	Сандал /дарга/	850,000.00	ширхэг	1	850,000.00
7	Хурлын ширээ	2,200,000.00	ширхэг	1	2,200,000.00
8	Хурлын сандал	207,000.00	ширхэг	10	2,070,000.00
9	Шкаф /3 хаалгатай/	880,000.00	ширхэг	1	880,000.00
10	Шкаф /2 хаалгатай/	492,000.00	ширхэг	1	492,000.00
11	Ширээ /оффис/	310,000.00	ширхэг	4	1,240,000.00
12	Сандал	207,000.00	ширхэг	4	828,000.00
13	Принтер /epson, өнгөт/	407,000.00	ширхэг	1	407,000.00
14	Принтер /samsung 2070 / 3 үйдэлтэй/	330,000.00	ширхэг	1	330,000.00
15	Компьютер /Dell/	1,397,000.00	иж бүрэн	3	4,191,000.00
16	Сейф /төмөр/	450,000.00	ширхэг	1	450,000.00
	Нийт дүн				22,658,000.00 (хорин хоёр сая зургаан зуун тавин найман мянган)